**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 08 өдөр  Дугаар А/424  Улаанбаатар хот

Ч.Нармандахыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсад албан томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төрийн албан тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.1. "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2011 оны 188 тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 133 дугаар захирамжаар байгууллагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтсан Виз, зөвшөөрөл, харьяатын газрын дарга Ч.Нармандахыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хот, Эрээн хотуудад 2019 оны 11 дүгээр сарын 08-наас 10-ны өдрүүдэд албан томилолтоор ажиллуулсугай.

2.Ч.Нармандахын томилолтын зардлын төсөв 1,490,000 /нэг сая дөрвөн зуун ерэн мянган/ төгрөгийг хавсралтаар баталж, зохих журмын дагуу тооцон албадан гаргах ажиллагааны зардлаас гаргахыг Санхүү, хангалт, үйлчилгээний газар /Б.Даваажав/-д зөвшөөрсүгэй.

3.Томилолтоор ажилласан дүнг буцаж ирснээс хойш ажлын 5 өдөрт багтаан удирдлагад илтгэх хуудсаар танилцуулахыг /Ч.Нармандах/-т даалгасугай.

ДЭД ДАРГА  Д.ТҮВШИНТӨР

D:\Alban bichig 2019\GIHG Tushaal 2019.docx

000001652

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2019 оны А/424 тоот тушаалын хавсралт

## БНХАУ-ЫН ХӨХ ХОТ, ЭРЭЭН ХОТУУДАД 2019 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 8-10-НЫ ӨДРҮҮДЭД ТОМИЛОЛТООР АЖИЛЛУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| № | Зардлын нэр | Хүний тоо | Хоногийн тоо | Тариф | Нийт /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Онгоцны тийз үнэ /УБ-Эрээн-УБ/ | 1 | | | 314,100 |
| 2 | Онгоцны тийз үнэ /Эрээн-Хөх хот-Эрээн/ | 1 | | | 310,814 |
| 3 | Зам, хоног: /БНХАУ-ын Хөх хот, Эрээн хот/ | 1 | 2 | 135,170 | 270,340 |
| 4 | Зочид буудал /БНХАУ-ын Хөх хот, Эрээн хот/ | 1 | 2 | 297,373 | 594,746 |
| 5 | | | | | |
| 6 | | | | | |
| | | | | | |
| | Нийт | | | | 1,490,000 |

Тайлбар: Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2011 оны 188 тоот тушаалын дагуу тооцов.
/Монгол банкны албан ханш 1ам доллар 2703.39₮, 1 юань 386.15/